



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 192


Улаанбаатар хот

“Опстра инвестмент менежмент” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.8, Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 4.8 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Опстра инвестмент менежмент” ХХК-д хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврыг үйл ажиллагаандаа баримталж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хөрөнгийг итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн явуулахыг “Опстра инвестмент менежмент” ХХК-д /Т.Жамсрандорж/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /В.Нэргүй/-т, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙНЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА



Э.БАТБОЛД